



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 09 өдөр

Дугаар A/114

Батноров сум

Сумын мэргэн цол олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 зүйлийн 8.4 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.5.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын тулгар төрийн 2234, Их Монгол Улсын 819, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 114, Ардын хувьсгалын 104 жилийн ой, Батноров сум үүссэн байгуулагдсаны 102 жилийн ойн үндэсний их баяр наадмаар Үндэсний шагай харвааны төрөлд амжилт үзүүлсэн дараах харваачдад цол чимэг олгосугай.

2. Батноров сум үүсэн байгуулагдсаны түүхт 102 жилийн ойн их баяр наадмаар Үндэсний шагайн харвааны төрөлд сумын мэргэн цол тэмдэг хүртсэн харваачдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Цол, чимгийг олгож холбогдох байгууллагад уламжлахыг Баяр наадам зохион байгуулах комиссын дарга (Д.Бямбацогт)-д үүрэг болгосугай.


ДАРГА



ОТГОНБАЯР

- 232530019

Батноров сумын Засаг даргын 2025 оны
07 дугаар сарын 09 өдрийн
А/114 дугаар захирамжийн хавсралт



СУМЫН МЭРГЭН ЦОЛ

1. Навааншарав Энхтайван
2. Энхтайван Амарсайхан
3. Оюунбаатар Мөнгөн-Өлзий